

unicef



НҮБ-ын Хүүхдийн Сан

**БҮХ ХҮНИЙГ
ТЭГШ ХАМРАХАД
ЧИГЛЭСЭН БОДЛОГО
БОЛОВСРУУЛАХАД
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ
ҮҮРЭГ: **МОНГОЛЫН
ХҮҮХЭД, ӨСВӨР
ҮЕИЙНХНИЙ ЭРХ****





**БҮХ ХҮНИЙГ
ТЭГШ ХАМРАХАД
ЧИГЛЭСЭН БОДЛОГО
БОЛОВСРУУЛАХАД
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ
ҮҮРЭГ: **МОНГОЛЫН
ХҮҮХЭД, ӨСВӨР
ҮЕИЙНХНИЙ ЭРХ****

© НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)
2020 он
Монгол улсад хэвлэв.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)
НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж - 14
Улаанбаатар 14201
Монгол Улс

Утас: (976-11) 312185, 312217
Факс: (976-11) 327313
www.unicef.mn



Хураангуй

Бодлогын энэ товч мэдээлэл нь, тэгш байдлын бодлого боловсруулалтыг дэмжихийн тулд нотолгоо бий болгох зорилгоор хамралт болон тэгш байдлыг хязгаарладаг хүчин зүйлийн хяналт үнэлгээний (Х\Ү) практикийн ач холбогдол, үндэслэлийг гаргаж байна. Тэгш байдлын концепцийг, хүүхэд, өсвөр үеийнхний эрх тэгш байдлыг хуулийн асуудал гэж үзэн, олон улсын болон Монголын хуулийн аль алинд шууд ил бус, гэхдээ гол үндсэн байр суурь болгож тусгасан байдаг. Гэвч, одоогийн хяналт үнэлгээний практик бол хүн амын бүх бүлгийг огт хамраагүй төдийгүй, тэгш байдалд учирч буй бэрхшээлийг тойрч байна. Хяналт үнэлгээг засгийн газар, байгууллагуудын хяналт үнэлгээний ердийн тогтолцоонд суулгаснаар шийдэгдэх боломжтой энэхүү асуудал нь хүүхэд, өсвөр үеийнхний эрхийг хэрэгжүүлэх хэрэгт түвэг учруулж байна.

1. Өмнөтгөл: Хүүхэд, өсвөр үеийнхний эрхийн хэрэгжилт ба тэгш байдал

Эрхэд суурилсан хөгжлийн хандлага нь, хүний эрхийг хүндэтгэх асуудлыг бодлогын тэргүүлэх чиглэл болгодог. Өнгөрсөн 10-аад жилд хүчин зүтгэл тавьснаар, олон улсын хөгжлийн болон төрийн бодлогын олон салбарын хамтран оролцогчид үүнийг хүлээн зөвшөөрсөн билээ (Корнволл ба Ниаму-Мүземби, 2004). Энэ арга хандлагын дагуу, хүний эрхийн хэрэгжилтийг гол үр дүн болгон хэрэгжүүлэхүйцээр төрийн бодлогыг боловсруулсан байх ёстой. Монголын хүүхэд, өсвөр үеийнхний эрхийн жишээ авч үзэхэд, тэдний эрүүл мэнд, эсэн мэнд амьдрах, боловсрол олох болон хөгжих, хамгаалуулах, оролцох эрх бодлогын тэргүүлэх хандлага болж хөгжсөн байна.

Аль аль нь зорьсон зорилгоо хэрэгжүүлэхий илэрхийлж буй учраас “үр дүн” ба “эрх” гэдэг үгийг харилцан орлуулж болохыг энд тэмдэглэх хэрэгтэй. Монголд 0-19 насны хүүхэд, өсвөр насныхны эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох хууль эрхийн хүрээ үндэсний түвшинд ч, олон улсын түвшинд ч байгаа. Энэ байдал нь эрхийн хэрэгжилтийг зөвхөн “хэрэгжвэл сайн” гэж үзэх мөрөөдлийн зүйл бус, харин хуулийн зорилго болгон тавьж байгаа ба, үүгээрээ хүрэх ёстой үр дүнг тодорхойлсон агуулгын хүрээг гаргаж байгаа юм. Хүүхэд, өсвөр насныхны хөгжил нь олон улсын хуулийн бодлогын хүрээнд, тухайлбал, 1989 оны Хүүхдийн эрхийн конвенцид (ХЭК), мөн 20 дугаар Ерөнхий тайлбарт, эрх хэмээн хамгаалахаар заасан. Олон улсын бусад хуулийн баримт бичигт, түүний дотор 1979 онд баталсан

Эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг асуудлыг хариуцсан хороо, 2011 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц (ХБИЭК), мөн, 2015-2030 оны Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүүхэд, өсвөр насныхны эрхийн талаар мэдээлэл багтдаг ба, эдгээрт нийгэм дэх нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хэм хэмжээг дээшлүүлэхэд хувь нэмэр болохуйц уялдаа холбоо бүхий хүчин чармайлтыг хамруулан тусган оруулсан байдаг.

Үндэсний түвшинд, хүүхэд, өсвөр насныхны эрхэд хамгийн хамаатай хуулийн баримт бичиг бол 1996 онд баталсан Хүүхдийн эрхийг хамгаалах хууль бөгөөд, түүний 4 дэх зүйлд “хүүхэд бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, төрсөн газар, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан ялгаварлан гадуурхагдахгүй, эрх тэгш байна” гэж тунхагласан байдаг. Энэ хууль хүүхдүүд “амьдрах”, “хөгжих”, “хамгаалуулах”, “оролцох” эрхтэй болохыг мөн тунхагласан (ОУХБ, 1996).

Хууль эрхийн хүрээний төвд хүний эрхийг зөвхөн хүн амын тодорхой зарим хэсэгт бус, бүх нийтэд хэрэгжүүлэх гол агуулга концепц нь оршдог. Тиймээс, “тэгш эрх гэдэг бол бүгд (хүмүүс), аливаа алагчлал, гадуурхал, бялдуучлалаас ангид, дүүрэн хангалуун байж, амьд явах, хөгжих боломжоор хангагдсан байхыг хэлнэ (НҮБХС, 2010). Тэгш байдлыг хангах нь бүх хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхийг шаардана. Цаашилбал, тэгш байдлыг хангахын төлөө чармайлт нь алсдаа тэгш эрхийг тогтоох ирээдүйд хүргэнэ.

Тэгш байдлын бүгдийг хамрах шинж чанараас үүдэн үзвэл, тэгш байдлыг тогтоох хүчин чармайлт, бодлого боловсруулах арга ажиллагааны тэгш байдал нь тэгш бус хандлагад өртөх магадлалд илүү мэдрэмжтэй байж, судалгаа болон тоо баримт мэдээлэл цуглуулах бусад механизмаас нэлээд тохиолдолд орхигдон хоцордог бүлгийг хамрахыг онцгой анхаардаг арга зам юм. Тиймээс, тэгш шинж чанар бүхий бодлого боловсруулахын тулд дараахь чиглэлээр нотолгоо баримт гаргаж тавихыг шаардана, үүнд, 1) тэгш байдалд учирдаг бэрхшээл саадад мэдрэг байдлыг тодорхойлох, 2) эмзэг буюу мэдрэг байдал нь, зарим үр дүнд хүрэх бололцоог хэр хэмжээнд хааж байгаад хийх дүн шинжилгээ, болон 3) орхигдон үлдсэн бүлэг, тэдний биелэгдээгүй эрэлт хэрэгцээг тодорхойлох. Тэгш бодлого

боловсруулах ажиллагаа нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах арга замыг эрхэмлэн үздэг тул, баримт нотолгоо цуглуулах, сан бүрдүүлэх ажиллагааг үүнд заавал тооцож үзэх нь зүйтэй.

2. Нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтын хяналт ба үнэлгээ

Тэгш бодлого боловруулах ажиллагаа нь нотолгоо, тоо баримтыг эрхэмлэдэг бөгөөд, тэгш байдлыг тогтоох явц нь, хяналт үнэлгээний (ХҮ)бодит ажиллагааг тоймлон дүгнэхээс эхэлнэ. Тэгш бодлого боловсруулах нь үндэсний хэмжээний байдлыг үнэн зөв төлөөлөх тоо баримт, нотолгоог цуглуулах, мөн, тэгш байдалд саад болж болох эмзэг (мэдрэг) байдлыг тодорхойлж, хүүхэд, өсвөр насныхны холбоотой үр дүн, уялдаа холбоог илрүүлэн гаргаж чадах тоо баримтад дүн шинжилгээ хийхээс ихээхэн хамааралтай. Одоогоор Монголд мөрдөж байгаа арга зам нь, нотолгоод суурилсан, тэгснээрээ тэгш бодлого боловсруулах боломжийг хэр хэмжээнд хангаж байгааг үнэлэх хяналт, үнэлгээний практик ажиллагаанд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

2.1. Орхигдож хоцорсон хүн амын хяналт үнэлгээ

Үр дүнг үнэлэхийн тулд, сайн боловсруулсан судалгаа, захиргааны нягт нямбай бүрдүүлсэн мэдээллийг ашиглан өргөн хүрээтэй хяналтын цогц ажиллагаа явуулах хэрэгтэй байна. Бүгдийг хамарсан хяналт энд чухал бөгөөд, жинхэнэ төлөөлөх чадвартай түүвэр нь хяналтын арга ажиллагааны үр дүнд хүн амын ямарч хэсгийг хэзээ ч орхигдуулахгүй байх үндэс юм.

Хэдийгээр, өрхийн төрөл бүрийн судалгаа, төрийн байгууллагуудын хөтөлдөг захиргааны тоо баримт зэрэг хэлбэрээр хяналт үнэлгээ өргөн хүрээнд явагддаг

боловч, хүүхэд, өсвөр насны хүн амын хувьд хяналтын явцын ялгаа зөрөө их, хяналт нь бүгдийг хамардаггүй зэргээрээ Монголын байдал бусад оронд байдагтай адил. Хүүхэд, өсвөр насны хүн амын зарим хэсэг орхигдох нь бий бөгөөд, энэ нь төлөөлөх чадвар муутай түүврийг бий болгох ба, тийм түүврийг ашигласан үнэлгээ мөн бүгдийг хамрах шаардлагыг бас хангахгүй. Бүгдийг хамраагүй хяналт үнэлгээ байгаа нь, бүрэн бус, хязгаарлагдмал баримт нотолгоо бий болгоход хүргэдэг, хэрэв бодлого боловсруулахад ашиглавал, тэгш бус бодлого гарах уршигтай.

Монгол улсын хувьд, одоогийн хяналт үнэлгээний практикт хаягдан үлддэг дараахь бүлэг хүмүүсийг тодорхойлж болно:

- 1. Тусгай байгууллагын халамжид байгаа хүүхэд, өсвөр насныхан**
- 2. Сургууль болон техникийн, мэргэжлийн боловсрол, сургалтын дотуур байранд байгаа хүүхдүүд**
- 3. Хэрэг зөрчилд холбогдсон хүүхдүүд**
- 4. Дотооддоо шилжин суурьшсан эсвэл хотод шилжин ирсэн бүртгэлгүй иргэд**

Үндэсний Статистикийн газар болон тэдний хамтрагч түншүүдийн явуулдаг өрхийн судалгаанд улсын тусгай байгууллагын халамж, болон хуулийн байгууллагын хараан дор байгаа хүүхдүүд хамрагддаггүй. Тэрчлэн, шилжин суурьшсан иргэд хяналтын уламжлалт бүртгэлийн ард орхигдон үлддэг. Үр дагаварт нь, тэдгээр бүлгийнхний үр дүн, тэгш байдлын хомсдолын эмзэг байдал мэдэгддэггүй, тэдний онцлог хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй болдог. Үнэн хэрэгтээ гаргаж өгсөн нотолгоо нь тэгш бус байдалд хохирол учруулж, улам гүнзгийрүүлсэн бодлого гаргахад хүргэх магадлалтай.


Сүүлийн үед судалгаа, бүртгэлээс байнга гадна орхигддог байсан хүн амын үл үзэгдэх бүлэг болох, хөдөлгөөний хязгаарлагдмал чадвартай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тодорхойлох талаар Монгол улс нэлээд ахиц олсон. Урьд нь, 2018 он хүртэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үр дүнтэй холбоотой тархалт, ялгааг тодорхойлох өргөн хүрээтэй баримт нотолгоо цуглуулах үйл явц

явагдаж байгаагүй. Одоогийн Олон үзүүлэлтэт түүвэр судалгаа (OYTC-MICS) 2018 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тоо баримт цуглуулсан, үндэсний түвшинд төлөөлөх чадвартай анхны судалгаа юм. Судалгаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Вашингтоны Бүлэг асуултууд болон, НҮБХС-аас боловсруулсан, харах, сонсох, өөрөө өөртөө үйлчлэх, харилцах зэрэг хязгаарлагдмал чадварын аль нь өөрт байгааг хариулагч этгээдийг өөрөө тодорхойлохыг хүсэх зэрэг дэмжих асуултуудыг ашигласан болно. Хөгжлийн бэрхшээлийг хянах нь, Монгол дахь хөгжлийн бэрхшээлийг илрүүлэн тодруулах, тэрчлэн тэдгээрт дүн шинжилгээ хийснээр тэгш үр дүнгийн төлөө нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад жинтэй нэмэр болох юм.

Тоо баримтын үнэлгээг өрхийн жилийн туршийн хөдөлгөөнт шинж чанарт мэдрэмжтэй явуулах хэрэгтэй. Жишээ нь, гол төлөв тодорхой хэдэн жилд нэг удаа явуулдаг өрхийн судалгаа түр зуурын өөрчлөлтийг илрүүлж чаддаггүй. Хөдөөгийн гэр орон алс хол байдаг, тэднийг дэмжих дэд бүтэц байхгүй учраас боловсрол эзэмшихийн тулд түр зуур шилжин суурьшдаг байдал нь тухайн гэр бүлийн байдлыг тодорхой цаг хугацаанд өөрчлөхөд хүргэдэг олон хүчин зүйлийн нэг юм. Цаашид, өрх, гэр бүл тусгаарлагдан, салангид амьдрах үйл явц Монголын хүүхдийн үр дүнд хэрхэн нөлөөлж, ямар үр дүнд хүргэдэг талаар, тухайлбал, үр нөлөө нь жендерийн ямар ялгаатай тусаж байгааг тодорхойлох судалгааг явуулах шаардлагатай. Тогтмол явуулдаг бүгдийг хамарсан хяналтын ажиллагаа нь дүн шинжилгээний баялаг бааз суурийг бий болгоно.

2.2. Эмзэг байдалд хийх дүн шинжилгээний хяналт, үнэлгээ

Figure 1: Water, sanitation and hygiene by education level of the household head



Note: This graph shows the percentage of households 1) using improved sources of drinking water, 2) using improved sanitation facilities which are not shared and 3) with a specific place for hand washing where water and soap or other cleansing agent are present, by education level of the household head. Source: Social Indicator Sample Survey 2018

Тэгш байдлын хязгаарлалтын эмзэг байдлын үр дүнгийн ялгааг тайлбарлаж болох ба тоо баримтын задаргаа хийхэд олонтаа ашигладаг (ҮСГ, 2015).

Ихэнхидээ, нийгэм-эдийн засгийн үр дүнг үндэсний статистикт нэгтгэж гаргасан байдаг ба энэ нь тэрхүү үзүүлэлтийн дунджийг илэрхийлдэг. Гэвч, нэгдсэн статистикийн үр дүнг гаргахад, хүн амын дунд оршин байж болох ялгаатай байдлыг далдлан бүрхэгдүүлэх магадлалтай.

Жишээ нь Монгол улсын хувьд, сайжруулсан ундны ус, сайжруулсан ариун цэврийн газар болон гар угаах байгууламжтай айл өрхийн эзлэх хувьд хийсэн дүн шинжилгээ, тэгш бус байдлын талаар ямарч нотолгоо бүрдүүлж чадахгүй. Гэхдээ, өрхийн тэргүүний боловсролын түвшин, (Зураг 1) зэрэг тэгш бус байдлыг харуулсан задаргаа бүхий тоо баримтад мөн ижил дүн шинжилгээ хийвэл, эрхээ хэрэгжүүлэх талаар илүү таагүй нөхцөлд байгаа, тодорхой бүлгийнхэнд чиглэсэн тэгш бодлого боловсруулахад бодлого боловсруулагчдад чухал дэм үзүүлнэ.

Монголд хүлээн зөвшөөрч, хэмжигддэг ялгаатай эмзэг байдлын үзүүлэлтэд, эрэгтэй эмэгтэй, орон байр, бүс нутаг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, өмчлөл, яс үндэс зэрэг ордог ба, гэхдээ, үүгээр ч хязгаарлагддаггүй. Тэгш бусын эмзэг байдал нь бодлого боловсруулагчдад зориулсан илүү ул суурьтай нотолгоо гаргаж өгөхийн тулд цаашид хяналт, үнэлгээний үйл ажиллагаа явуулахыг шаардаж байна, үүнд:


Шилжилт хөдөлгөөн:

- Хот сууринд шилжсэн бүртгэлгүй хүүхдүүд/эсвэл эдийн засгийн дотоодын шилжилтэд хамаарагчид, ихэнхи тохиолдолд тухайн газар нутагт бүртгэгдээгүй байдгийн улмаас төрийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдмал байдаг. Ажил хийхээр шилжсэн хүүхдүүд ч, ажлын хүнд нөхцөлд ажиллах, бага цалин хөлстэй байх зэрэг нөхцөлд ордог төдийгүй, цаашдаа, боловсрол дорой, хөгжилд нөлөөлөх бусад хүчин зүйлээс шалтгаалан үр дүн муу болох нь бий.

Яс үндэс:

- Эрүүл мэнд, боловсрол бол хамгааллын холбоотой олон үзүүлэлтээр, казак, цаатан гэх мэт үндэсний цөөнхи тэргүүлсэн өрхийн хүүхдүүдийг таагүй нөхцөлд байгаа гэж тооцдог. Гэвч, үндэсний цөөнхийг судлахдаа, бага хэмжээтэй түүврийг сонгодог нь, статистикийн хувьд ач холбогдолтой нотолгоо боломжгүйг илтгэх учир, баталгаатай дүгнэлт гаргадаггүй. Хоёрдугаарт, хяналт үнэлгээний ажиллагаа нь хүн амын зарим хэсгийг орхигдуулах, далдлах боломжтой, жишээ нь “хамгийн их төлөөлөх чадвартай үндэсний” судалгаанууд зөвхөн Монгол хэл дээр явагддаг. Тиймээс, нотолгоо бүрдүүлэхэд учирч буй энэ саад нь тэгш бодлого боловсруулах хүчин чармайлтыг сулруулдаг

Зураг 2: 5-17 настай хүүхдүүдийн дунд ажил хэрэг гүйцэтгэх, сургуульд сурахад тохиолддог бэрхшээл



Note: This graph shows the percentage of children and adolescents age 5-17 years that have difficulties with various functions by whether they are attending school. Source: Multiple Indicator Cluster Survey 2018.

Хөгжлийн бэрхшээл: Одоо хөгжлийн бэрхшээлийг эмзэг байдлын дүн шинжилгээний хяналтад оруулдгийг бид өмнө нь тэмдэглэсэн. Ингэснээр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн харьцангуй хэрэгжилтийг үнэлэх баримт нотолгоог гаргаж тавьдаг. 2018 оны ОУТС (MICS 2018)-аар сургуульд сурдаггүй хүүхэд, өсвөр насныхныг, сургуульд сурдаг үеийнхэнтэй нь харьцуулахад, ажил хэрэг гүйцэтгэх чадвар нь хязгаарлагдмал байх магадлал өндөр байдгийг илрүүлсэн билээ (Зураг 2). Энэ нь шинэ модулийн олон үр дүнгийн дүгнэлтүүдийн нэг болох бөгөөд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хандах, хамруулах бодлогыг боловсруулахад бодлого боловсруулагчдад дэмжлэг болох юм.

Эмзэг нөхцөл байдлууд нөхцөлдөн давхцах нөхцөлд, тэртэй тэргүй аль нэгэн талаар эмзэг бүлэгт багтаж байгаа хүмүүсийн байдлыг улам хүндрүүлж болох талаар ойлголт Монголд дутагдалтай байна. Жишээ нь хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дэд бүтэц байхгүй алслагдсан газар амьдардаг бол, тэд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ авахад харьцангуй хүндрэл ихтэй, хүүхдийн хөгжлийн бэрхшээл, алслагдсан байдал хоёрын хоорондын харилцан үйлчлэл

хүүхдийн амьдрах, эрүүл мэндийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг улам хүндрүүлэх магадлал өндөр. Цаашид, хяналт, үнэлгээний үйл ажлыг хэрэгжүүлбэл, тэдгээр харилцан үйлчлэлийг үнэлж дүгнэх болон тоо хэмжээг тодорхойлох боломжтой болно..

3. Тэгш бөгөөд НОТОЛГООНД тулгуурласан бодлого боловруулалтын хяналт, үнэлгээг зохион байгуулалтад оруулах тухай

тодорхойлох төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй. Үнэлж дүгнэх үзүүлэлтүүдийн хүрээг гаргах, тэдгээрийг хэрхэн хянах, яаж үнэлэх талаар албан ёсны гэрээ байгуулах нь зүйтэй. Хяналт үнэлгээг зохион байгуулалтад оруулах нь хяналт, үнэлгээний хүрээнд бий болгосон баримт нотолгоог хэрхэн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд хүргэх төлөвлөгөө гаргахыг шаардана.

Монголын хүүхэд, өсвөр насныхны эрхийг хэрэгжүүлэхэд, тодорхой өөрийн гэсэн үйл ажиллагааг, урт удаан хугацаанд тогтвортой явуулах чадамж бүхий хяналт үнэлгээний (Х\Ү) зохион байгуулалттай бүтэц бүхий тогтолцоо шаардлагатай юм. Гарсан баримт нотолгоо нь тэгш бодлого боловсруулахад дорвитой хувь нэмэр оруулах боломжтой.

Хяналт үнэлгээний үйл явцыг сайжруулах нь Монголын хүүхдүүдэд тэгш байдлыг бүрдүүлэхэд чухал болохыг ярилцсан. Хэрэв тоо баримт цуглуулах ажиллагаа нь хүн амын ил харагддаггүй бүлгийг хамарч, тоо баримтын дүн шинжилгээнд эрхийн хэрэгжилт нь бусадтай харьцуулахад таагүй нөхцөлд байгаа хүн амын эмзэг байдлын бүх хэлбэрийг илрүүлэн гаргадаг болсон нөхцөлд тэгш байдлыг тогтоох боломжтой.

Хяналт үнэлгээний бүгдийг хамарсан үйл явцыг Монголын засгийн газрын бүх байгууллагуудын зохион байгуулалтын бүтцэд нэгтгэн оруулах нь хамгийн чухал бөгөөд, яаралтай хийх ажил юм. Хэн хяналт үнэлгээний ажиллагааг хариуцан явуулах, эдгээр төрөл бүрийн байгууллагууд бие биеэ хэрхэн нөхөн ажиллах зэрэг байгууллага хоорондын, байгууллагын доторхи үүрэг, хариуцлагыг


4. ЗӨВЛӨМЖҮҮД

- » Хүүхэд, өсвөр насныхны тэгш байдлыг үр дүн нь хууль ёсны асуудал бөгөөд, тиймээс, тэгш, баримт нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулах ажиллагаа туйлын амин чухал болж байна;
- » 0-19 насны хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй бодлого боловсруулахын тулд, хүүхэд, өсвөр насны хүн амын статистикаар ил гарч харагддаггүй хэсгийг хүлээн зөвшөөрч, дүн шинжилгээ хийдэг, бүгдийг илүү хамарсан хяналт үнэлгээг хэрэгжүүлэх шаардлагатай;
- » Хүүхэд, өсвөр насныханд нөлөөлдөг үр дүн болон тэгш байдлын саад бэрхшээлийг харилцан нөлөөллийг үнэлж дүгнэх хэрэгтэй байна. Дараа нь баримт нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулахыг дэмжихийн тулд, эмзэг байдал, үр дүнгийн ялгаатай байдлыг хамарсан дүгнэлт гаргаж чадахуйц хяналт үнэлгээг явуулах нь зүйтэй;
- » Тэгш бөгөөд баримт нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулахад чиглэсэн тогтвортой хүчин чармайлт, хариуцлагыг баталгаажуулахын тулд хяналт үнэлгээний үйл явцыг засгийн газрын тогтолцооны бүтцэд суулгах

Бодлогын энэхүү товч тайлбарыг НҮБХС-аас 2019 онд Хөгжлийн зам (Development Pathways)-тай хамтран Өсвөр насныхны цогц хөгжлийн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан гаргасан болно.

Лавлагааны бусад материалууд

- Корнвелл, Андрей болон Селестин Ниаму- Муземби. 2004. “Эрхэд суурилсан арга зам хандлагыг” хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд тусгахуй. *Third World Quarterly* 25 (8): 1415–1437. Холбоосоос үз: <<https://doi.org/10.1080/0143659042000308447>>. Accessed 31 July 2019.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага. 1996. Монгол улс ба Хүүхдийн эрхийг хамгаалах хууль. Холбоосоос үз : <https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_lang=&p_isn=78391&p_classification=04>. Accessed 31 July 2019.
- Монголын Үндэсний Статистикийн Газар. 2015. Монголын нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2013. Олон үзүүлэлтэт түүвэр судалгаа. Эцсийн тайлан.
- Нэгдсэн Үндэстэн. 2011. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц болон Нэмэлт протокол.
- Нэгдсэн Үндэстэн. 1989. Хүүхдийн эрхийн конвенц.
- Нэгдсэн Үндэстэн. 1979. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц.





НҮБ-ын Хүүхдийн Сан

© НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)

2020 он

Монгол улсад хэвлэв.

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)

НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж - 14

Улаанбаатар 14201

Монгол Улс

Утас: (976-11) 312185, 312217

Факс: (976-11) 327313

www.unicef.mn